

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД
НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ**

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/д	Шалгуур үзүүлэлт
1.1	Эцэг/эхийн нэр: Жамсрандорж Нэр: Дэлгэрсайхан
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлийн гишүүн
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <i>тийм</i> Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <i>үгүй</i>
1.4	Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; .санхүүгийн удирдлагын магистр зэрэгтэй -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; <i>Тийм</i> -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; <i>Тийм</i> -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; <i>Тийм</i> -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ.

	<ul style="list-style-type: none"> • албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно); <p style="text-align: center;"><i>СЭЗИС-д 1996 оноос хойш Санхүүгийн Удирдлагын тэнхимд харъяалагдан ажилласан. 2008 оноос эхлэн төсөв, мөнгөний бодлого, макро эдийн засгийн чиглэлээр сургалт, судалгааны чиглэлээр ажиллаж 20 орчим судалгааны төсөлд оролцсон.</i></p>
1.5	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; <ul style="list-style-type: none"> • 2019 он, “Монгол Улсын төсөв, мөнгөний бодлогын шинжилгээ” Судалгааны ажил/Судалгааны багийн ахлагч – Катовест Менежмент ХХК Агуулга: Төсөв, мөнгөний бодлогын шинжилгээ, дүгнэлт • 2019 оны 10 сар, “Монгол Улсын төсвийн удирдлагад нөлөөлөх улс төрийн нөлөө, бууруулах арга зам” Судалгааны ажил/Судалгааны багийн гишүүн - Герман Монголын Хамтын ажиллагааны нийгэмлэг КАС Агуулга: Улсын төсвийн төлөвлөлт, хэрэгжилтэд үзүүлэх улс төрийн нөлөөлөлийг тодорхойлох, • 2019 он, “Монгол Улсын Төсөв-Мөнгөний бодлогын хэрэгжилт, харилцан хамаарал, эдийн засагт үзүүлэх нөлөө” Судалгааны ажил/Илтгэл – Катовест Менежмент ХХК Агуулга: Төсөв, мөнгөний бодлогын хослол, түүний оновчтой байдал, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, • 2018 он, “Монгол Улсын төсөв түүний бизнесийн орчинд үзүүлэх нөлөө Судалгааны ажил/Судалгааны багийн ахлагч - МҮХАҮТанхим Агуулга: Төсвийн бодлогын эдийн засаг, бизнесийн орчинд үзүүлэх нөлөөлөл, • 2018 он, “Монгол Улсын төсөв, татварын орлогын шинжилгээ, Судалгааны ажил/Судалгааны багийн ахлагч – Нээлттэй нийгэм хүрээлэн Агуулга: Төсвийн орлого, түүний бүтэц, хандлага • 2018 он, “Монгол улсын өрийн бүтэц, төсвийн судалгаа” Ном /Хамтран зохиогч/ - Далай ван аудит ХХК Агуулга: Монгол Улсын өрийн өнөөгийн байдал, эрсдэл, зөвлөмж • 2018 он, “Монгол улсын татварын орчин, төсөвт үзүүлэх нөлөө” Эрдэм шинжилгээний өгүүлэл - Economic Analytica Улс төрийн эдийн засаг судлал сэтгүүл Агуулга: Татварын орчны өнөөгийн байдал, татварын төсвийн бодлогод үзүүлэх нөлөөлөл Холбоо барих: СЭЗИС

	<ul style="list-style-type: none"> • 2017 он, “Монгол улсын төсвийн орлого, зардал, төлөвлөлтийн өнөөгийн байдал сайжруулах арга зам ” судалгааны ажил/ багийн ахлагч – СЭЗИС Агуулга: Төсвийн төлөвлөлтийг сайжруулах арга зам • 2015 он, Мөнгөний бодлогын бие даасан хараат бус байдлыг үнэлж, бодлогын зөвлөмж гаргах” Судалгааны тайлан/багийн ахлагч – СЭЗИС Агуулга: Төв банкны бие даасан хараат бус байдлын түвшинг тодорхойлж зөвлөмж боловсруулах Холбоо барих: СЭЗИС • 2010 он, “Монгол улсын төсвийн зарлага, түүний хандлага, бүтэц” - судалгааны илтгэл – ЗГазар Агуулга: Төсвийн зарлагын өөрчлөлт, түүний шалтгаан, хандлага
<p>1.6</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ.</p> <p style="text-align: center;"><i>Байхгүй</i></p>
<p>1.7</p>	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл -Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын өр ном - https://itoim.mn/article/nfg83/13237 Зургийг энэхүү файлд хавсаргав 2. Монгол Улсын төсвийн удирдлагад нөлөөлөх улс төрийн нөлөө, бууруулах арга зам судалгааны ажил - Зургийг энэхүү файлд хавсаргав.

	<p>3. Монгол Улсын Төсөв-Мөнгөний бодлогын хэрэгжилт, харилцан хамаарал, эдийн засагт үзүүлэх нөлөө – Судалгааны ажлыг емейлээр илгээлээ.</p> <p>4. https://ikon.mn/opinion/2zyz https://montsame.mn/mn/read/330493 https://www.mongolianminingjournal.com/a/73196 https://ergelt.mn/news/20/single/37177 https://itoim.mn/article/QtyGCc/20652 https://news.zindaa.mn/4ctl</p>
1.8	<p>Эрүүгийн хариуцлага Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ <p style="text-align: center;">Үгүй</p> </p>
1.9	<p>Сахилгын шийтгэлийн талаар Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх <p style="text-align: center;">Үгүй</p> </p>

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p>
2.1	<p>Монгол Улсын төсвийн тогтвортой байдлын асуудал 2010 оноос эхлэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд тусгагдан 2013 оноос бүрэн хэрэгжиж эхлэхээр төлөвлөгдсөн байсан. Гэхдээ энэ хүрээнд зөвхөн төсвийн алдагдал, зарлага, өр, болон орлогын ерөнхий дүрмүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байсан билээ. Гэсэн хэдий боловч 2013 оноос эхэлсэн эдийн засгийн хямрал, төсөв, өрийн буруу удирдлагаас улбаалан энэ ерөнхий дүрмүүд хүртэл өнөөг хүртэл хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна. Үүнээс шалтгаалан төсвийн зарлагын хэт тэлэлт, зарлагын оновчгүй хуваарилалт, өрийн дарамт нэмэгдэх зэргээр төсвийн хүрээнд зохисгүй үр гарахаас гадна төсвийн бодлогын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үр ашиг нэмэгдэхгүй байх зэрэг ихээхэн сөрөг үр дагавар бий болж байгаа юм. Үүний нэг илрэл нь бид сүүлийн 11 жилд 20 их наяд орчим төгрөгийн алдагдал бий болгож, сүүлийн 7 жилд 24 их наяд төгрөгийн өр, хүү төлөөд байна. Энэ их мөнгөний ард үр дүн, үр ашиг хэмээх үзүүлэлтийг анхаарах шаардлагатай.</p> <p>Миний хувьд төсвийн тогтвортой байдал гэдгийг дээрх дэлхий нийтээр мөрдөгдөж буй гол дүрмүүдээс гадна бодлогын, зарлагын бүтцийн, чиглэлийн гэх мэт цогц тогтвортой байдал хэмээн ойлгодог. Мөн сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны ажил, ажиглалтын үр дүнд төсвийн тогтвортой байдлыг бий болгохын тулд институцийн шинэчлэлийг хийх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Иймээс ТТБЗөвлөлийг шинэчлэн зохион байгуулах, эрх зүйн статусыг сайжруулах, бие даасан хараат бус зөвлөлийн түвшинд хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байгаад хувь хүний зүгээс таатай хандаж байгаа. Тиймээс дээрх нөхцөл байдлыг арилгах, төсвийн тогтвортой байдлыг хангахын төлөө өөрийн ажлын</p>

тодорхой хэсгийг хандуулах нь улс орны эрх ашиг, хувь хүний мэргэжлийн зорилгод ихээхэн ихээхэн нийцэх ажил юм.

Энэ ажилд томилогдвол хуулийн хүрээнд төсвийн тогтвортой байдлыг сахин хамгаалах үүргийг гүйцэтгэхээс гадна төсвийн тогтвортой байдал гэдгийг улс орны эдийн засгийн хөгжил, нийтийн язгуур эрх ашгийн төлөө байлгах томоохон зорилгын хүрээнд цогцоор харан ажиллахыг хичээнэ. Энэ хүрээнд төсвийн дүрмүүдийг мөрдүүлэхийг хичээхээс гадна төсвийг алдагдалгүй болгох, орлогын эх сурвалжийг нэмэгдүүлэх, зарлагын оновчтой тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг анхааран ажиллах болно.

Өнөөдөр төсвийн тогтвортой байдал алдагдаж байгаа үндсэн шалтгаан нь эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдлаас гадна улс төрийн өндөр нөлөөлөл, сонгуулийн тогтолцоо, улс төрийн амлалт зэрэгтэй холбоотой хэмээн үзэж улс төр, нам, төрийн байгууллагын үйл ажиллагаанаас ангид ажиллахыг зорино.

Энэхүү бодлого чиглэлийн хүрээнд эдийн засаг, төсөв, эдийн засаг, уул уурхай гэх мэт чиглэлээр судалгаа шинжилгээний ажлуудыг үргэлжлүүлэн хийж түүнд суурилсан төсвийн бодлого, шийдвэр гаргалтын суурийг бэлтгэнэ. Багийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөлийн гишүүд, ажлын алба, судалгааны багтай хамтран ажиллаж үр дүнд хүрэхийг зорих болно.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Жамсрандорж

Өөрийн нэр: Дэлгэрсайхан

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2023 оны 12 сарын 06

--- оОо ---